



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 14 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 14 дүгээр хуралдааныг 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 14 дүгээр хуралдаанаар “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн төслийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны 11 тогтоолыг батлан шийдвэрлэж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай удирдамж, чиглэлийг холбогдох ажлын хэсэгт өгөхөөр тогтов.

ХХЗХ-ноос Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/45 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл” болон Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалтын баримт бичгийг боловсронгуй болгох, батлуулах арга хэмжээг үе шаттай авч байгаа болно.

Энэхүү арга хэмжээний хүрээнд тус хорооны 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 94 тоот “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн батлах тухай тогтоол, 2023 оны 106 тоот тогтоолын хавсралтаар “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” баримт бичгийг батлаад байна. Хорооны даргын 2023 оны А/279 тоот тушаалаар “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсгээс дээрх хууль тогтоомж, бодлогын баримт бичиг ба тогтоолоор баталсан зохицуулалтын баримт бичигт нийцүүлж, батлагдсан тушаалын удирдамжийн хүрээнд “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн төсөл, танилцуулга, холбогдох тогтоолын төслийг тус тус боловсруулан зохицуулах хорооны 2023 оны ээлжит 14 дүгээр хуралдаанд хэлэлцүүлэв. Тус баримт бичгийн төслийн талаар 2023 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 06 дугаар “Хорооны хуралдаанаас баримт бичгийн төслийн талаар өгсөн удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэх тухай (5G)” хуралдааны Тэмдэглэл гаргаж, хорооны хуралдааны үеэр дарга, гишүүдээс гарсан санал зөвлөмжийг баримт

бичгийн төсөлд тусгах, найруулга редакцыг хуульд нийцүүлэн боловсруулах, холбогдох удирдамж, чиглэлийг ажлын хэсэг /З.Амгалан/-т даалгахаар тогтож, “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн төслийг Хорооны дараагийн ээлжит хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Энэхүү хорооны 2023 оны ээлжит 14 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 11 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 11 тусгай зөвшөөрлийн тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 127 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 128 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 129 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Бокс фокс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 130 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Хай бокс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 131 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Вертексмон ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 132 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь

заалт, Цахим амьдрал ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 133 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Халиун кабель ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 134 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 135 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 1 дугаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 136 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 1 дугаар ашиглалтын хугацааг сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Түмэн ресурс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 137 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай дугаар ашиглах бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-11-04